



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлагууд болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журам, аргачлалын талаар сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Ш.Үнэнтөгс/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /П.Цэрэнлхам/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/212 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх түр журам”, 2020 оны А/60 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний түр журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторовын
2022 оны 01 дүгээр сарын 01 өдрийн
А/16 дугаар тушаалын хавсралт



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн аудитын байгууллагын стратеги зорилт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал, шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төсөл, хөтөлбөр түүний явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Төрийн аудитын байгууллагын бодлого, төлөвлөлт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулахад оршино.

1.3. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг Үндэсний аудитын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.

Хоёр. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

2.1. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.1.1. шударга, хараат бус байх;
- 2.1.2. ил тод, нээлттэй байх;
- 2.1.3. шалгуур үзүүлэлт, тоо баримт, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 2.1.4. үр дүнд чиглэсэн, нотлогдохуйц байх;
- 2.1.5. тасралтгүй байх;
- 2.1.6. бүх талын оролцоог хангасан байх;
- 2.1.7. үнэн зөв байдлыг хариуцдаг байх.

Гурав. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилт багтана.

3.1.1. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа дараах хууль тогтоомж, тушаал шийдвэр хамаарна:

- 3.1.1.1. Монгол Улсын хууль;
- 3.1.1.2. Улсын Их Хурлын тогтоол;
- 3.1.1.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;
- 3.1.1.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;
- 3.1.1.5. Монгол Улсын Засгийн газрын тогтоол (Хуульд заасны дагуу төрийн албанд нийтлэг мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр);
- 3.1.1.6. Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал, шийдвэр, өгсөн үүрэг даалгавар.

3.1.2. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа дараах бодлогын баримт бичиг хамаарна:

- 3.1.2.1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал;
- 3.1.2.2. Төрийн аудитын байгууллагын стратеги;
- 3.1.2.3. Төрийн аудитын байгууллагын тухайлсан үйл ажиллагааны чиглэлээр батлагдсан стратегиуд;
- 3.1.2.4. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт;
- 3.1.2.5. Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (INTOSAI), Азийн аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага (ASOSAI)-аас гаргасан стратеги, үзэл баримтлал, тунхаглал, суурь зарчмууд.

3.1.3. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны хүрээнд дараах баримт бичиг хамаарна:

- 3.1.3.1. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн тухайн жилийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- 3.1.3.2. Төрийн аудитын байгууллагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл;
- 3.1.3.3. Ил тод байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл;
- 3.1.3.4. Дэмжих үйл ажиллагааны чиглэлээрх арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл.

3.2. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах үйл ажиллагаа хамаарахгүй:

- 3.2.1. Аудитын чанарын хяналт, баталгаажуулалт;
- 3.2.2. Аудитын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилт;
- 3.2.3. Албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүйтэй холбогдсон асуудал;
- 3.2.4. Төрийн аудитын байгууллагын дотоод аудит;

Дөрөв. Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

4.1. Үндэсний аудитын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Төрийн аудитын байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулж биелэлтэд нь хяналт тавих, тайлагнах, мэдээлэх үүргийг хариуцна.

4.2. Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан нэгж нь Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний суурь болон хүрэх түвшинг тооцон үнэлэгдэхүйц хэмжээнд боловсруулж, Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг аргачлал, арга зүйгээр хангаж ажиллана.

4.3. Үндэсний аудитын газрын захиргаа, удирдлага хариуцсан нэгж нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг улирал тутам авч нэгтгэнэ.

4.4. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилт, нэмэлт тайлбар, тодруулга, санал гаргах ажлыг тухайн чиг үүргийн зохион байгуулалтын нэгж хариуцна.

4.5. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр өөрчлөлт орсон бол тухайн нэгж ажлын 5 хоногийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид мэдэгдэж, зөвшөөрлийн дагуу цахим системд бүртгэнэ.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх, үүрэг

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч нь дараах эрхтэй байна:

5.1.1. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбоотой мэдээлэлтэй танилцах;

5.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материал, тайлбар, тодруулга, санал асуулгыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.1.3. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч нь дараах үүрэгтэй.

5.2.1. Хууль тогтоомж, Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн мөрдөх ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;

5.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах;

5.2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомжид үндэслэн энэ журмын 2.1-т заасан зарчмыг баримтлан гаргах;

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг төлөвлөх, хийх, хэрэгжүүлэх

6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө байна.

6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал, баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

6.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь Төрийн аудитын байгууллагын бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд улирал тутам явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ, хагас болон бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан бэлтгэнэ.

6.4.Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд улирал тутам, дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөний биелэлт болон төсөл, хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтэд тухайн баримт бичигт тусгагдсан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр гарсан дүгнэлт, зөвлөмж, тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тушаалаар баталгаажуулж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.

6.6.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд туссан дүгнэлт, зөвлөмжид үндэслэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.6.1.Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сургалт зохион байгуулах;

6.6.2.Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем

7.1.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал шийдвэр, үүрэг даалгавар, төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийг бүртгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт тавих, ашиглах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системийг ашиглана.

7.2.Хэрэгжилтийн тайланг цахим системд бүртгэхдээ тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.

7.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системийн ажлын даалгаврыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, түүнд орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн тухай бүр Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

7.4.Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь цахим системийн хөгжүүлэлт цахим системийн хэвийн, тасралтгүй ажиллагааг хариуцна.

7.5.Цахим системд мэдээлэл бүртгэж байгаа газар, нэгж, албан тушаалтан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

7.6.Цахим системийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг дараах зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд хариуцна.

7.6.1.Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь цахим систем, програм хангамж, системийн зохицуулалт, нэвтрэх эрх олгох асуудлыг хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн зөвшөөрлийн дагуу зохицуулах;

7.6.2.Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нь цахим системд өөрт олгосон эрхийн дагуу хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын заалт нэг бүрийг цахим мэдээллийн системд бүртгэх, тайлагнах хугацаа, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх;

7.6.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжийн албан хаагч нь цахим системд өөрийн эрхийн дагуу нэвтэрч, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тушаал шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

7.6.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж цахим системийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.

7.7.Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага болон тухайн асуудал хариуцсан албан хаагч цахим системтэй холбоотой дараах асуудлыг хариуцна.

7.7.1.Цахим системд нэвтэрч, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын өөрсдийн чиг үүрэгт холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг заасан хугацаанд бүртгэх;

7.7.2.Холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй тухай бүр танилцаж, өгсөн санал, зөвлөмжийг мөрдөж ажиллах.

7.8.Цахим систем нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулсан нээлттэй хэсэгтэй байна.

Найм. Хариуцлага

8.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад дараах зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд Төрийн аудитын тухай болон холбогдох бусад хуульд зааснаар хариуцлага тооцуулах саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлнэ.

8.1.1.Мэдээ, тайланг худал зөрүүтэй тайлагнасан, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавиагүй, удаа дараа буруу гаргасан, хоцроосон, тайлбар нотлох баримтыг тогтоосон хугацаанд ирүүлээгүй;

8.1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.

“Төрийн аудитын байгууллагын
хяналт-шинжилгээ, үнэлгээний
журам”-ын хавсралт

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Төрийн аудитын байгууллагын стратеги, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, нэгжийн чиг үүрэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал, шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд энэ аргачлалыг баримтална.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг
хэрэглэх, хамрах хүрээ**

2.1.Төрийн аудитын байгууллагад хэрэгжих хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг дараах хүрээнд ашиглана. Үүнд:

- 2.1.1. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаа;
- 2.1.2. Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт;
- 2.1.3. Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал, Удирдлагын зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.

2.2.Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын үйл ажиллагааг дараах үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ.

- 2.2.1. Батлагдсан чиг үүрэгт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг үндсэн үйл ажиллагаанд тооцож 70 оноо;
- 2.2.2. Төрийн аудитын байгууллагад мөрдөгдөж байгаа урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 10 оноо;
- 2.2.3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 10 оноо;
- 2.2.4. Дэмжих үйл ажиллагааг 10 оноо;

**Гурав. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн
нэгжүүдийн үйл ажиллагааны дараалал, шалгуур үзүүлэлт**

3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд арга хэмжээний гүйцэтгэлийн шалгуур нь дараах чанарыг агуулна.

- Найдвартай байдал: Ижил нөхцөл байдалд ижилхэн дүгнэлт хийх;
- Бодит байдал: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх урьдчилсан байр сууринаас ангид байх;
- Ойлгомжтой байдал: Тодорхой илэрхийлэгдсэн бөгөөд хэт өөр байдлаар тайлбарлах боломжгүй байх.

3.1.1. Гүйцэтгэлийн шалгуур нь тоон ба чанарын хэмжүүрүүд агуулсан байна.

3.2. Аудитын үе шат, гүйцэтгэлийн хувь, шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно:

Хүснэгт 1

д/д	Аудитын төрөл	Аудитын үе шат, эзлэх хувь				ЧБГ-аас өгсөн үнэлгээ*
		Төлөвлөлт-ийн өмнөх	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Тайлагнал	
1	Санхүүгийн тайлангийн аудит					
1.1	Төсвийн шууд захирагч	10	30	40	20	үгүй
1.2	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	10	30	40	20	үгүй
1.3	Засгийн газрын тусгай сан	10	30	40	20	үгүй
1.4	Төсвийн төвлөрүүлэн захирагч	10	30	40	20	үгүй/тийм
1.5	Төсвийн ерөнхийлөн захирагч	10	30	40	20	тийм
1.6	Түүврийн байгууллага	х	х	100	х	үгүй
1.7	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан	10	30	40	20	тийм
1.8	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл	10	30	40	20	тийм
1.9	Завсрын аудит	х	х	100	х	үгүй
2	Улсын нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит	10	30	40	20	тийм
3	Гүйцэтгэлийн аудит	20	40	30	10	тийм
4	Нийцлийн аудит					
4.1	Нийцлийн аудит /шууд тайлагнах/	20	40	30	10	тийм
4.2	Нийцлийн аудит /нотлох ажил/	20	40	30	10	тийм
5	Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудит	х	40	40	20	тийм
6	Гүйцэтгэх ажиллагаанд зарцуулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх аудит	х	х	х	х	үгүй
7	Төлөвлөгөөт бус аудит	х	30	40	30	үгүй
8	Чанарын баталгаажуулалт	10	40	30	20	үгүй
9	Хяналт-шинжилгээ	10	10	50	30	үгүй

Тайлбар: х- хамааралгүй

3.3. Аудитын чанарыг аудитын үе шат түүнд хэрэгжүүлэх ажилбарын тоонд үндэслэн гүйцэтгэлийн хувиар үнэлж дараах байдлаар тогтооно*:

Хүснэгт 2

№	Аудитын төрөл	Үзүүлэлт	Аудитын үе шатны ажилбарын тоо				Ажлын нийт тоо	
			Төлөвлөлтийн өмнөх	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Тайлагнал		
1	Нотлох ажилд хамаарах санхүүгийн тайлангийн аудит	Ажилбарын тоо	5	5	6	5	6	27
		Хувь	18.5	18.5	22.2	18.5	22.2	100.0

2	Нотлох ажилд хамаарах нийцлийн аудит	Ажилбарын тоо	1	15	6	11	2	35
		Хувь	2.9	42.9	17.1	31.4	5.7	100.0
3	Шууд тайлагнах ажилд хамаарх гүйцэтгэлийн аудит	Ажилбарын тоо	11	12	8	13	3	47
		Хувь	23.4	25.5	17.0	27.7	6.4	100.0

3.4. Аудитын тайлагналын дараах үе шатны гүйцэтгэлийн чанарын шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

3.4.1. Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь өмнөх оны үзүүлэлтээс 3-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байх;

3.4.2. Үр өгөөжийн биелэлт нь бүртгэсэн өгөөжийн 80 хувиас доошгүй хувийг хүлээн зөвшөөрүүлсэн байх эсхүл төсвийн урсгал санхүүжилтийн 1 төгрөгт ноогдох үр өгөөж нь өмнөх оноос нэмэгдсэн байх.

3.5. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан аудитын болон дэмжих үйл ажиллагааны арга хэмжээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно.

3.5.1. Байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, төрийн аудитыг чадавхжуулах, хөгжүүлэх судалгаа шинжилгээ хийх, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-1;

3.5.2. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд хүний нөөцийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, захиргааны болон санхүү, нийтлэг үйлчилгээг хариуцан зохион байгуулах нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-2;

3.5.3. Аудитын явц, гүйцэтгэлийн талаарх өгөгдөл мэдээлэлд тулгуурлан аудитыг байнгын нэгтгэсэн хяналт, удирдлагаар хангаж, аудитын ерөнхий бодлого, чиглэлийг тодорхойлох, түүний үр дүнг харилцагч талуудад нэгтгэж тайлагнах асуудлыг хариуцсан нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-3;

3.5.4. Нотлох ажилд хамаарах аудитыг хариуцсан нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-4;

3.5.5. Шууд тайлагнах ажилд хамаарах аудитыг нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-5;

3.5.6. Тусгай болон төлөвлөгөөт бус аудитыг хариуцсан нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-6;

3.5.7. Төрийн аудитын байгууллагын ил тод байх зарчимд тулгуурласан харилцагч талуудын харилцаа, хамтын ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-7;

3.5.8. Төрийн аудитын байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийг удирдах ажлыг нэгтгэн зохион байгуулах нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-8;

3.5.9.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд чанарын баталгаажуулалт хийх чиг үүргийг хариуцаж зохион байгуулах нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-9;

3.5.10.Төрийн аудитад мэдээллийн технологийн дэвшилтэт арга нэвтрүүлж, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх нэгжийн шалгуур үзүүлэлтийг Маягт-ШҮ-10.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй, аргачлал

4.1. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ **урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн** дагуу гүйцэтгэлийн бодит хүрсэн үр дүнг төлөвлөсөн зорилт (суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин)-той харьцуулах, холбогдох баримт бичиг, мэдээ тайланг **судлах, харьцуулан шинжлэх** зэрэг хяналт-шинжилгээ, үнэлгээний аргуудыг хэрэглэн үнэлнэ.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

4.2. Зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоон болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг дараах аргачлалаар тооцно:

4.2.1. “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол **100** хувь (90-100);

4.2.2. “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалт, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол **80** хувь (70-89);

4.2.3. “хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол **50** хувь (40-69);

4.2.4. “хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол **0** хувь (0-39);

4.2.5. “үнэлэхгүй”-эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухайн зорилтыг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулсан, хүчингүй болгосон бол үнэлэхгүй.

4.3. Төрийн аудитын байгууллагын бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу энэ журмын 4.1, 4.2 -т заасан аргачлалаар, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал, шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд энэ журмын 4.2-т заасан аргачлалаар үнэлнэ.

4.4. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг дараах байдлаар тодорхойлно:

- 4.4.1. **90-100** оноо авсан бол “**A**” буюу “Маш сайн”;
- 4.4.2. **80-89** хүртэл оноо авсан бол “**B**” буюу “Сайн”;
- 4.4.3. **70-79** хүртэл оноо авсан бол “**C**” буюу “Хангалттай”;
- 4.4.4. **50-69** хүртэл оноо авсан бол “**D**” буюу “Дутагдалтай”;
- 4.4.5. **0-49** хүртэл оноо авсан бол “**F**” буюу “Хангалтгүй”.

4.5. Үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, биелэлт, хүрсэн үр дүнг хангалтгүй, тодорхой бус, тоо хэмжээг буруу тайлагнасан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг удаа дараа хангалтгүй хэрэгжүүлсэн, биелэлтийг ирүүлээгүй, тогтоосон хугацаанд засварлаж тайлагнаагүй бол үнэлгээг **(0-3)** оноогоор хорогдуулан үнэлэх үндэслэл болно.

4.6. Тухайн нэгжийн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч цаг үеийн шаардлагаар гүйцэтгэсэн үүрэг даалгаврыг үр дүнтэй биелүүлсэн, шилдэг арга барил, тэргүүн туршлага, шинэ санаа нэвтрүүлсэн нь үр дүнд хүрсэн бол үнэлгээг **(0-3)** оноогоор нэмэгдүүлэн үнэлэх үндэслэл болно.

4.7. Удирдлагын шийдвэрээр болон гадаад, дотоод нөлөөллийн хүчин зүйлээс шалтгаалан тухайн арга хэмжээ хэрэгжих боломжгүй эсхүл хэрэгжүүлэх хугацааг хойшлуулсан тохиолдолд бодит шалтгааныг тогтоосны үндсэн дээр үнэлгээнд нөлөөлүүлэхгүй байж болно.

4.8. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд тушаал шийдвэрийн хэрэгжилтийг /Маягт-ТШХ/-аар тайлагнана.

4.9. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний нэгтгэлийг /Маягт-НМ-1/-аар, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний нэгтгэлийг /Маягт-НМ-2/-аар тус тус нэгтгэнэ.

4.10. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн дэмжих болон аудитын үйл ажиллагааг дараах маягтын дагуу дүгнэж, гүйцэтгэлийг хувиар илэрхийлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ. Үүнд:

4.10.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан нэгж нь:

- 4.10.1.1. Статистик мэдээ гаргалтын байдал Маягт-СМ-1
- 4.10.1.2. Сургалтын үйл ажиллагааны үр дүн Маягт СҮА-2
- 4.10.1.3. Үйл ажиллагааны тайлагнал Маягт-ҮА-3

4.10.2. Захиргаа, удирдлага хариуцсан нэгж нь:

- 4.10.2.1. Төсвийн шууд захирагч нарын шилэн дансны үйл ажиллагаа Маягт-ШД-4
- 4.10.2.2. Төсвийн шууд захирагч нарын төсвийн зарцуулалт, санхүүгийн тайлагнал Маягт-ТЗСТ-5
- 4.10.2.3. Хүний нөөцийн үйл ажиллагаа Маягт-ХН-6
- 4.10.2.4. Хуулийн хэрэгжилт хангаж ажилласан байдал Маягт-ХХ-7
- 4.10.2.5. Архивын үйл ажиллагаа Маягт-АҮА-8
- 4.10.2.6. Албан хэрэг хөтлөлт Маягт-АХХ-9

4.10.3. Үндэсний аудитын газрын аудит хийх үүрэг бүхий бүтцийн нэгж өөрийн хариуцах асуудлын хүрээний хамаарал бүхий аудитын талаар:

4.10.3.1. Аудитын нэгдсэн удирдлага Маягт-АНГ-10

4.10.3.2. Нотлох ажилд хамаарах аудит Маягт-АХГ-11

4.10.3.3. Шууд тайлагнах ажилд хамаарах аудит Маягт-АГГ-12

4.10.3.4. Тусгай болон төлөвлөгөөт бус аудит Маягт-АДГ-13

4.10.4. Чанарын баталгаажуулалт хариуцсан нэгж нь:

4.10.4.1. Чанарын баталгаажуулалтын Маягт-ЧБ-14

4.10.5. Харилцаа хамтын ажиллагаа хариуцсан нэгж нь:


4.10.5.1. Мэдээллийн ил тод байдал Маягт-ХХА-15

4.10.6. Мэдээллийн технологи хариуцсан нэгж нь:

4.10.6.1. Цахим систем ашиглалтын үйл ажиллагаа Маягт-МТ-16

4.11. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгжүүдээс ирүүлсэн тайлан, нотлох баримтад тулгуурлан үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийн үр дүнд шинжилгээ хийж үнэлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээр нь тулган баталгаажуулж болно.

---oOo---



ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТ	Процесс	Гүйцэтгэл тооцох хувь	Шалгуур үзүүлэлт-1	Шалгуур үзүүлэлт-2	Шалгуур үзүүлэлт-3
1	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны төсвийн төсөл, сарын бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн хагас болон жилийн эцсийн нэгтгэсэн тайлан хуулийн хугацаанд хүргүүлэх	Төсвийн шууд захирагчдын саналыг хүлээн авч, нэгтгэн боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байх	30	Хугацаа	Хүргүүлсэн албан бичиг /огноо, дугаар/, албан захидал	Мэдээллийг шаардлагад нийцүүлэн хүлээн авч нэгтгэсэн эсэх
		Төсвийн шууд захирагчдаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянаж нэгтгэн, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яаманд хүргүүлсэн байх	20	Хугацаа	Хүргүүлсэн албан бичиг /огноо, дугаар/, албан захидал	Үнэн зөв
		Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланг хүлээн авч, хянаж нягтлан, нэгтгэн, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан гарган, Сангийн яаманд хүргүүлсэн байх	40	Хугацаа	Хүргүүлсэн албан бичиг /огноо, дугаар/, албан захидал	Үнэн зөв
		Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлэн, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байх	10	Хугацаа	Хүргүүлсэн албан бичиг /огноо, дугаар/, албан захидал	Бүрэн гүйцэд
		Гүйцэтгэл /нийт/	100			
2	ТАБ-ын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах болон шинжээч сонгон шалгаруулах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулах	Төсвийн шууд захирагчид болон төрөлжсөн аудитын газруудаас хөрөнгө оруулалтын саналыг авч нэгтгэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, удирдлагад танилцуулан батлуулж, tender.gov.mn сайтад байршуулсан байх	10	Хугацаа	Хүргүүлсэн албан бичиг /огноо, дугаар/, албан захидал	Цахим сайтад байршуулсан мэдээлэл
		Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолтыг хариуцсан нэгжээр гаргуулан, үнэлгээний хороо байгуулан, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, үр дүнг олон нийтэд мэдээлж, шилэн дансанд байршуулсан байх	30	Хугацаа, Тушаал	Гэрээ	Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийн тоо
		Худалдан авах ажиллагааны тайланг хагас жил, жилийн эцсээр Сангийн яаманд хүргүүлсэн байх	10	Хугацаа	Албан бичиг /Огноо, дугаар /	Цахим сайтад байршуулсан мэдээлэл
		Шинжээч сонгон шалгаруулах ажлын саналыг харьяа газруудаас авч, саналыг нэгтгэн, төлөвлөгөө боловсруулан, удирдлагаар танилцуулан, батлуулсан байх	10	Хугацаа	Тушаал /Огноо, дугаар /	Үнэн зөв, бүрэн
		Төлөвлөгөөний дагуу ажлын даалгаврыг захиалагч нэгжээр гаргуулан авч, үнэлгээний хороо байгуулан, шинжээч сонгон шалгаруулах ажиллагааг журмын хүрээнд зохион байгуулсан байх	30	Хугацаа	Тушаал	
		Шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааны үр дүнд шалгарсан хувь хүн, баг, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх	10	Хугацаа	Шалгарсан этгээдийн судалгаа	Гэрээний дугаар, огноо
		Гүйцэтгэл /нийт/	100			

		Гүйцэтгэл /нийт/	100			
3	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Тухай бүр мэдээлэх найман мэдээг хугацаанд нь мэдээлсэн байх	30	Хугацаа	Үнэн зөв	Бүрэн гүйцэл
		Сар бүр мэдээлэх гурван мэдээг сар бүр мэдээлсэн байх	15	Хугацаа	Үнэн зөв	Бүрэн гүйцэл
		Улирал бүр мэдээлэх нэг мэдээг улирал бүр мэдээлсэн байх	5	Хугацаа	Үнэн зөв	Бүрэн гүйцэл
		Хагас жилд мэдээлэх дөрвөн мэдээг мэдээлсэн байх	20	Хугацаа	Үнэн зөв	Бүрэн гүйцэл
		Бүтэн жилээр мэдээлсэн байх арван нэгэн мэдээг бүрэн мэдээлсэн байх	30	Хугацаа	Үнэн зөв	Бүрэн гүйцэл
		Гүйцэтгэл /нийт/	100			
Сургалт, хөтөлбөрт хамрагдах албан хаагчдыг сонгох, тэдгээрийн мэдээлэл, холбогдох бичиг баримтыг бэлтгэх болон оролцох боломж нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Сургалтын жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулахад хамтран ажиллах	15	Хугацаа			
	Сургалт, хөтөлбөрт оролцогчдыг сонгоход санал авах ажлыг зохион байгуулах	30	Хугацаа	Нэгжээс санал авсан байх		
	Сургалт, хөтөлбөрт оролцогчдын мэдээлэл, бичиг баримтыг бүрдүүлэх	60	Хугацаа	мэдээлэл бодит байдалд нийцсэн, иж бүрэн байх		
	Сургалтад оролцох бэлтгэл ажлыг нэгжийн зүгээс хангах	100	Хугацаа	бэлтгэлийг бүрэн хангасан байх		
Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, ХАСХОМ тайланг АТГ хүргүүлэх	ТАБ-ын ХАСХОМ гаргах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 10-ны дотор АТГ-т хүргүүлэх	40	Хугацаа	нэрсийг бүрэн гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байх		
	Мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах	80	Хугацаа	мэдээлэл хууль тогтоомжид нийцсэн байх		
	Мэдүүлгийн тайланг нэгтгэн АТГ-т хүргүүлэх /2022.03.01-ний дотор/	100	Хугацаа	тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байх		
Төрийн аудитын байгууллагын удирдах гүйцэтгэх албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг АТГ-т хүргүүлж хянуулах ажлыг зохион байгуулах	ТАБ-т томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг цахимд үүсгэх	20	Хугацаа	цахим системд мэдүүлгийг үүсгэсэн байх		
	Мэдүүлэг гаргагчид мэдэгдэх	40	Хугацаа	мэдүүлэг гаргагчид мэдэгдсэн байх		
	Мэдүүлгийг үнэн зөв бүрэн бөглүүлэх	70	Хугацаа	мэдүүлэг үнэн зөв бүрэн бөглөх талаар арга зүйн дэмжлэг үзүүлсэн байх		
	Мэдүүлгийг баталгаажуулах	90	Хугацаа	тухайн албан хаагч болон хариуцсан албан хаагч баталгаажуулсан байх	Гарын үсэг зуруулж баталгаажуулсан баталгааны хуудас, бүртгэл	
	АТГ-т илгээсэн байх	100	Хугацаа	Хүргүүлсэн албан бичиг /огноо, дугаар/, албан захидал		
Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах арга зүйн зөвлөгөө өгөх	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	80	Хугацаа	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх шторк, сурталчилгааны материал	тухайн албан хаагчид биечлэн өгсөн зөвлөгөө	
	Сургалт зохион байгуулах	100	Хугацаа	Шинээр томилогдсон болон нийт албан хаагчдад жилд 2-оос доошгүй сургалт зохион байгуулсан байх	Сургалтын материал, Сургалтад хамрагдсан бүртгэл	

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангахад чиглэсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тайлагналыг авч нэгтгэн АТГ-т хүргүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах	50	Хугацаа	Төсөл боловсрогдсон байх	
	Санал авах	60	Хугацаа	Удирдлага болон бүтцийн нэгжээс санал авсан байх бүтцийн нэгж	
	Батлуулах	70	Хугацаа	Тухайн оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлуулж, байгууллагын цахим хуудаст байршуулах	
	Хүргүүлэх	80	Хугацаа	АТГ-т хүргүүлсэн байх	
	Хэрэгжилтийн тайланг авч нэгтгэх	90	Хугацаа	бүтцийн нэгжүүдээс тайлан авч нэгтгэсэн байх	
	АТГ-т хүргүүлэх	100	Хугацаа	тухайн оны 6 дугаар сарын 30-ны өрийн дотор хүргүүлж, дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор АТГ-т хүргүүлэхбэлтгэл хангасан байх	
Төрийн албаны зөвлөлийн сургалт, Удирдлагын академийн төрийн албан хаагчийн чиглүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх багц сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах	Удирдлагын академид суралцуулах албан хаагчийн судалгаа гаргах	30	Хугацаа	Суралцах албан хаагчийн нэр гарсан байх	
	Суралцуулах тухай хүсэлт хүргүүлэх	60	Хугацаа	Удирдлагын академид хүсэлт хүргүүлсэн байх	
	Суралцагчийг сурч буй эсэхэд хяналт тавьж товчлосон хугацаанд сурч төгсөх талаар мэдэгдсэн байх	80	Хугацаа	Уулзах ярилцах, эсхүл мэдэгдэл өгсөн байх	
	Академаас ирүүлсэн хуваарийн дагуу албан хаагчдыг суралцуулах	100	Хугацаа	Тухайн онд суралцах албан хаагчид сургалтад бүрэн хамрагдаж төгссөн байх	
Удирдах ажилтны зөвлөгөөний хөтөлбөр, зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулж хэрэгжүүлэх	Зөвлөгөөний бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж, удирдлага, нэгжийн дарга нараас санал авч, тусгаж батлуулах	30	Хугацаа	Төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл	
	Зөвлөгөөн зохион байгуулах байр, танхим, техник хэрэгсэл, оролцогчдын нэр, байрлуулах буудал, санхүүжилтийг шийдвэрлэх	60	Хугацаа	Бэлтгэл ажил хангагдсан байх	
	Зөвлөгөөн зохион байгуулах	100	Хугацаа	Зөвлөгөөн зохион байгуулсан байх	
ТАБ-ын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах	Сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах удирдамжийг МУЕА-аар батлуулах	30	Хугацаа	Удирдамж	
	Сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах бэлтгэл ажил хангах	50	Хугацаа	бэлтгэл ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн байх	
	Шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн иргэн, албан хаагчийг бүртгэх	80	Хугацаа	иргэн албан хаагчдын бичиг баримт бүрэн бүрдүүлж, бүртгэл гарсан байх	
	Сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах	100	Хугацаа	Шалгалт зохион байгуулсан тайлан, тогтоол албажсан байх	
	Албан тушаалын зэрэг дэв олгох саналыг ТАБ-ын хэмжээнд авч нэгтгэн хянах	50	Хугацаа	Санал авч, хянасан байх	

ТАБ-ын албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох үйл ажиллагааг зохион байгуулах	Удирдлагад танилцуулсан байх	60	Хугацаа	Танилцуулсан байх	
	МУЕА-ын шийдвэрийн төсөл бэлтгэж санал авах	80	Хугацаа	Төсөл бэлтгэж, санал авсан байх	
	МУЕА-ын шийдвэрээр зэрэг дэв олгох	100	Хугацаа	Зэрэг дэв олгох асуудал шийдвэрлэгдсэн байх	
ТАБ-ын тангараг өргөх үйл ажиллагааг зохион байгуулах	ТАБ-ын албан хаагчийн тангараг өргөх албан хаагчийн нэр, удирдамж, хөтөлбөр батлуулах	30	Хугацаа	тангараг өргөх албан хаагчийн нэр, удирдамж, хөтөлбөр батлагдсан байх	
	Тангараг өргүүлэх байр танхим, техник хэрэгсэл, Тангарагийн хуудас хэвлүүлж бэлтгэх	50	Хугацаа	Бэлтгэл ажил хангагдсан байх	
	Албан хаагчдыг "Тангараг өргүүлэх тухай" тушаалыг албажуулах	80	Хугацаа	Тушаал албажсан байх	
	Ёслолын ажиллагааг зохион байгуулах	100	Хугацаа	Ёслолын арга хэмжээ зохион байгуулагдсан байх	
Шагнаж, урамшуулах асуудлыг хэлэлцэж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Шагнаж урамшуулах асуудлыг ТАБ-ын хэмжээнд санал авах	50	Хугацаа	Саналыг бүрэн авсан байх	
	Ирүүлсэн саналыг комиссоор хэлэлцэх	80	Хугацаа	Комисс хуралдаж тэмдэглэл гарсан байх	
	Шагналын тодорхойлолтыг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлэх	100	Хугацаа	Холбогдох байгууллагад хүргэгдсэн байх	
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгох ажлыг зохион байгуулах	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох албан хаагчийн судалгаа гаргах	50	Хугацаа	Судалгаа гарсан байх	
	Нэмэгдэл олгох шийдвэрийн төсөл бэлтгэж холбогдох албан тушаалтнаас санал авах	80	Хугацаа	төсөлд холбогдох албан тушаалтнаас санал авсан байх	
	Нэмэгдэл олгох тухай МУЕА-ийн тушаалыг албажуулах	100	Хугацаа	МУЕА-ийн тушаал албажуулсан байх	
ТАЗ-ийн мэдээллийн системд албан хаагчийн мэдээллийг оруулах, тайлан өгөхөд бэлтгэх	ТАЗ-ийн мэдээллийн системд албан хаагчийн мэдээллийг оруулах	80	Хугацаа	ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл орсон байх	
	Тайлан өгөх бэлтгэл хийсэн байх /Тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор өгдөг/	100	Хугацаа	Бэлтгэл ажил хийгдсэн байх	
ТАБ-ын албан хаагчийн мэдээллийн санг хөтлөн явуулах, албан хаагчийн судалгааг нас, хүйс, боловсрол, мэргэжил, мэргэшил, нас, шагнал, нийгмийн баталгааны судалгаа гаргах	Аймаг, Нийслэл дэх ТАГ-ын хариуцсан албан хаагчид мэдээллийн сантай ажиллах талаар арга зүйн зөвлөмжийг тухай бүр утсаар болон цахимаар өгөх	30	Хугацаа	Албан хаагчдад зөвлөгөөг цахим болон утсаар өгсөн байх	
	ТАБ-д ажиллаж байгаа нийт албан хаагчийн мэдээллийг санд оруулах	80	Хугацаа	Ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл орсон байх	
	Албан хаагчийн судалгааг нас, хүйс, боловсрол, мэргэжил, мэргэшил, шагналын тайлан гаргах	100	Хугацаа	Холбогдох тайлан гарсан байх	
Нийгмийн хамгааллын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах /ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр ТАТХ 55.3/	Хөтөлбөрийн төсөл бэлтгэх	30	Хугацаа	Хөтөлбөрийн төсөл боловсруулсан байх	
	Төсөлд удирдлага, нэгжийн дарга нараас санал авч тусгаж тушаалын төсөл бэлтгэх	50	Хугацаа	Санал авч, тушаалын төсөл боловсруулсан байх	
	МУЕА-ын тушаалаар хөтөлбөрийг батлуулах	100	Хугацаа	Хөтөлбөр батлагдсан байх	
Нийгмийн асуудал шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдөл хүсэлтийг бүртгэж,	Нийгмийн асуудлаар ирүүлсэн өргөдлийг бүртгэж, нэгдсэн судалгаа гаргаж удирдлагад танилцуулах	60	Хугацаа	өргөдлийг дэвтэрт бүртгэж, судалгаа гарсан байх	

шийдвэрлүүлэх асуудлыг зохион байгуулах	Нийгмийн асуудал шийдвэрлэх тухай МҮЕА-ын тушаал гаргах	100	Хугацаа	МҮЕА-ын тушаалаар асуудал шийдвэрлэгдсэн байх	
Албан бичгийн цахим бүртгэл хөтлөх	Албан бичгийн цахим бүртгэл хөтлөх	100	Хугацаа	Бүртгэл хөтөлсөн байх	
	хөтлөөгүй	0		цахим бүртгэлгүй	
Албан бичгийн цаасан суурьтай бүртгэл хөтлөх	Албан бичгийн цаасан суурьтай бүртгэл хөтлөх	100	Хугацаа	Бүртгэлийн дэвтэргэй байх	
	хөтлөөгүй	0		бүртгэлийн дэвтэргүй	
Хариутай бичигт хяналт тавих	Хариутай бичгийн хоцролтын талаар тухайн нэгжид мэдэгдэх	100	Хугацаа	Хоцролтын талаар тухайн нэгж, албан хаагчид мэдэгдсэн бүртгэлийн дэвтэр хөтөлсөн байх	
	мэдэгдээгүй	0		бүртгэл хөтлөөгүй	
ТАБ-ын хэмжээнд арга зүйгээр хангах	ТАБ-ын хэмжээнд арга зүйн сургалт эсвэл зөвлөмж өгөх	100	Хугацаа	Сургалт эсхүл зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн байх	
	Өгөөгүй	0		энэ талаар арга зүйгээр хангаагүй	
Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тайлагнах	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тайлагнах	100	Хугацаа	Бичиг хэргийн эргэлтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж шуурхайд болон улирал, хагас бүтэн жилээр гаргах	
	гаргаагүй бол	0		тайлан мэдээ гараагүй	
ТАБ-ын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлуулах	ТАБ-ын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлуулах	100	Хугацаа	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг тухайн оны I дүгээр сард батлуулсан байх	
	Батлуулаагүй	0		батлуулаагүй	
ТАБ-ын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бичиг баримт хүлээн авах	ҮАГ-ын бүтцийн нэгжээс баримт бичгийг хүлээн авах	80	Хугацаа	Тухайн оны I дүгээр улиралд бүх баримтыг авч дууссан байх	
	Нэгжээс архивт өгөх баримт ирүүлээгүй тохиолдолд тухайн нэгжид энэ талаар мэдэгдэж шинжээчийн зүгээс шаардлага тавих	100	Хугацаа	Баримт өгөөгүй нэгжид мэдэгдэх хуудас хүргүүлсэн байх	
Архивын сан хөмрөг бүрдүүлэх	Архивын нөхөн бүрдүүлэлт хийх	100	Хугацаа	Нөхөн бүрдүүлэлт хийсэн байх	
	бүрдүүлээгүй	0		нөхөн бүрдүүлэлт хийгээгүй	
Архивын баримтыг цахимжуулах	Архивын баримтыг цахимжуулах ажлыг төлөвлөгөөний дагуу хийх	100	Хугацаа	төлөвлөсний дагуу цахим баримт бүрдсэн байх	
	Цахимжуулаагүй	0		цахимжуулаагүй	
Архивын цаасан суурьтай бүртгэл хөтлөх	Архивын цаасан суурьтай бүртгэл хөтлөх	100	Хугацаа	Цаасан суурьтай баримтын бүртгэл хийгдсэн байх	
	бүртгэл хөтлөөгүй	0		бүртгэл хөтлөөгүй	
Архивын үйл ажиллагааг тайлагнах	Архивын үйл ажиллагааг тайлагнах	100	Хугацаа	Архивын үйл ажиллагааны тайланг улирал хагас бүтэн жилээр бичсэн байх	
	тайлагнаагүй	0		Тайлагнаагүй	
ТАБ-ын албан хэрэг бичгийн хөтлөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн төлөвлөгөөнд санал өгөх	10			

5	ТАБ-ын албан хаагч ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан хууль эрх зүйн актыг сурталчлах, мэдээлэл өгөх	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг цахим орчинд байршуулах	10	Хугацаа	ТАБ-ын албан хаагч ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэгээ сэргийлэх хууль эрх зүйн актыг сурталчлах, мэдээлэл өгсөн байна	
		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	40			
		Ёс зүй, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гарын авлага бэлтгэн гаргах	40			
		Гүйцэтгэл	100			
6	ТАБ-ын төрийн болон албаны нууц хамгаалах дотоод журмын хэрэгжилтийг хангах	Төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууц хамгаалах ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх	10	Хугацаа	огноо, дугаар	
		Хууль тогтоомжид заасны дагуу албан хаагч бүрээс төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг гаргуулах	30	Хугацаа	баталгааны маягт	
		Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын төслийг боловсруулж Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулан хэрэгжүүлэх	30	Хугацаа	Тушаал	
		Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтнуудад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх сургалт зохион байгуулах	30	Хугацаа	сургалтын он, сар, өдөр	
		Гүйцэтгэл	100			
7	ТАБ-ын эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль, хяналтын бүх шатны байгууллагад итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	ТАБ-ын эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль, хяналтын бүх шатны байгууллагад итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох итгэмжлэлийн төслийг боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудитораас итгэмжлэл авах	20	Хугацаа	гомдол, нэхэмжлэл, хүсэлт, хариу тайлбар, албан бичиг	Итгэмжлэл
		Шүүх хуралдаанд товлогдсон хугацаанд оролцох	30	Хугацаа	шүүх хуралдааны он, сар, өдөр	
		Хуулийн хүрээнд шүүхийн шийдвэр гаргуулах	50	Хугацаа	шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	
		Гүйцэтгэл	100			
8	Төрийн аудитын албан хаагчийн аливаа нөлөөллөөс ангид байхуйц нэмэлт баталгаагаар хангах, зөвлөмж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төрийн аудитын албан хаагчаас нөлөөллийн мэдүүлэг бөглүүлэх	50	Хугацаа	нөлөөллийн мэдүүлэг	
		Хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх	50	Хугацаа	зөвлөгөө авсан албан хаагчийн тоо	
		Гүйцэтгэл	100			
9	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн явцын талаар мэдээлэл солилцох уулзалтуудыг зохион	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн судалгааг гаргах	20	Хугацаа	судалгааны нэгтгэл	
		Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар албан бичгийн төсөл боловсруулан удирдлагад танилцуулан холбогдох газарт хүргүүлэх	30	Хугацаа	албан бичгийн огноо, дугаар	

	байгуулах	Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагуудтай хамтран хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн явцын талаар мэдээлэл солилцох уулзалтуудыг зохион байгуулах	50	Хугацаа	уулзалт болсон газрын нэр, огноо	
		Гүйцэтгэл	100			
10	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн болон нөлөөллийн мэдүүлэг, ЗЕХ-ийн /103 дугаар зүйл/ асуудлуудаар зөрчлийн сан үүсгэж нэгдсэн бүртгэл хөтөлж, тайлагнах	Аудит хийх явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	40	Хугацаа	албан бичгийн огноо, дугаар	
		Төрийн аудитын газрын хэмжээнд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасан төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн судалгааны маягтыг шинэчлэн боловсруулах	10	Хугацаа	Шинэчилсэн маягт	
		Шинэчлэн батлагдсан судалгааны маягтын дагуу Төрийн аудитын байгууллагын хэмжээнд судалгааг гаргуулан авч нэгтгэх	10	Хугацаа	судалгааны нэгтгэл	
		Судалгааг Төрийн аудитын тухай хуульд зааснаар цахим санд байршуулах	40	Хугацаа	аудит.мн цахим хуудас дахь мэдээлэл	
		Гүйцэтгэл	100			
11	Захиргааны акт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хяналт тавих, санал зөвлөмж хүргүүлэх тогтсон горим тогтолцоо бий болгож баталгаажуулах, бусад нэгжид дэмжлэг үзүүлэх	Захиргааны актын төслийн хууль эрх зүйн үндэслэл хянах	30	Хугацаа	захиргааны актын тоо	
		Захиргааны актын төслийн хууль эрх зүйн үндэслэл хянаж санал боловсруулж хүргүүлэх	30	Хугацаа	захиргааны актын төсөлд өгсөн актын тоо	
		Бусад нэгжид хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	40	Хугацаа	үйлдсэн баримт бичгийн тоо	
		Гүйцэтгэл	100			
12	ТАБ-аас батлан гаргасан эрх зүйн актуудыг ангилан бүртгэж, эрх зүйн баримт бичгийг системчлэн хадгалах сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, шинэчлэх, боловсронгуй болгох ажлыг хэрэгжүүлэх	Монгол Улсын Ерөнхий аудитораас гаргасан эрх зүйн актуудыг ангилан бүртгэх	30	Хугацаа	ABLE системд байршуулсан тушаалын тоо	
		Эрх зүйн баримт бичгийг системчлэх хадгалах	30	Хугацаа	цаасан болон цахим баримтын тоо	
		Олон нийтэд байршуулах шинэчлэх, боловсронгуй болгох	40	Хугацаа	legalinfo.mn, audit.mn	
		Гүйцэтгэл	100			
13	ТАБ-д ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлтэд хяналт тавьж зохион байгуулах	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах	10	Хугацаа	Бүртгэлийн дэвтэр	
		Хүсэлтийг цахим файл үүсгэх	10	Хугацаа	able програм	
		Цахим санд бүртгэх	30	Хугацаа		
